

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА  Ж.ГАНБААТАР

2022 оны 10 дугаар сарын 15.

УДИРДАМЖ

2022 оны 10 дугаар сарын 14

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ хийх, ажлын үр дүнг
үнэлэх тухай

Зорилго: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын
үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах

Хугацаа: 2022 оны 11 дүгээр сарын 01-05

Ажиллах багийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Гантулга

Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн
дарга

Гишүүд:

Ш.Эрдэнэжаргал

Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн
Хууль, эрх зүйн хэлтсийн
ахлах мэргэжилтэн
Санхүү, төрийн
сангийн хэлтсийн
мэргэжилтэн

Ж.Ганбаяр

Х.Баярбаатар

Хамрах хүрээ: Мөрөн, Баянхутаг, Батноров, Хэрлэн сумдын ЗДТГ, төсөвт
байгууллагууд

Хяналт- шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилт
- Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
- Төрийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал
- Байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний
хаорондын уялдаа
- Захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмжийн биелэлтэд
хяналт тавьж, зөвлөн туслах
- Архив, албан хэрэг хөтлөлт
- Төсвийн орлогын биелэлт

8. ОНХС-ийн журмын хэрэгжилт
9. Сумын удирдлагууд болон гүйцэтгэгч компаниудтай уулзалт хийж, тухайн суманд баригдаж байгаа барилга, объектын гүйцэтгэлийн явцтай танилцаж ашиглалтад орох эцсийн хугацааг объект тус бүрээр тодорхойлон жагсаалт үйлдэх
10. Khentii.mn сайтад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт оруулсан эсэх
11. Үнэлгээний төхөөрөмжийн хэрэгжилт /бичлэг ухрааж үзэх бөгөөд илэрсэн зөрчлийн дагуу шууд арга хэмжээ тооцох/
12. Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт /төсөвт бүх байгууллага/
13. Хяналтын хуудасны журмын хэрэгжилт /төсөвт бүх байгууллага/

Анхаарах асуудал:

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэн үнэлгээ өгнө.
- Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.
- Дүнгийн хуралд нийт албан хаагчдыг бүрэн хамруулна.
- Хяналт-шинжилгээний дүнг удирдлагын зөвлөлд ажлын 7 хоногт багтаан танилцуулж, дүгнэлт зөвлөмж хүргүүлнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС